



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/274

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "а", "Малын генетик нөөцийн тухай хуулийн 6.3, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.30.1, "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.1.13 дахь зорилтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үржилд ашиглаж буй хээлтүүлэгч, цөм сүргийн малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг мэргэжил арга зүйгээр ханган, дүн тайлан мэдээг гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Мөнхтөр -Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд:

Х.Цэнгэлсайхан -Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга

М.Баасанжаргал -Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн

Б.Пүрэвдорж -Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн


Б.Батбилэг -Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн

Л.Мягмарцэцэг -Хүнс, хөдөө аж ахуйн газрын Захиргаа аж ахуйн мэргэжилтэн

2. Үржилд ашиглаж буй хээлтүүлэгч, цөм сүргийн малыг ялган тэмдэглэх ажлыг холбогдох журам, заавар, гэрээний дагуу ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх ажлыг сумын Хөдөө аж ахуйн тасгийн мал зүйч, сумдын Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгжүүдээр гүйцэтгүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Ялган тэмдэглэж, бүртгэлжүүлсэн хээлтүүлэгч, цөм сүргийн малыг бүртгэл мэдээллийн нэгдсэн санд хамруулсан ажлын тайланг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд 2019 оны 10 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Мөнхтөр/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 21 өдөр

Дугаар А/273

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3"а", Малын генетик нөөцийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээний нийт мал сүргийн генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Мөнхтөр

-Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга

Нарийн бичгийн дарга:

Х.Цэнгэлсайхан

-Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны дарга

Гишүүд:

М.Баасанжаргал

-Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн

Б.Пүрэвдорж

-Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн

Б.Батбилэгт

-Хүнс, хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албаны мэргэжилтэн

2.Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх ажилд сумдын Хөдөө аж ахуйн тасгийн мал зүйчдийг шуурхай удирдлагаар ханган, Хүнс хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн яамнаас ирүүлсэн аргачлалын дагуу аймгийн хэмжээний малтай өрх, аж ахуйн нэгж, байгууллагын мал сүрэгт хийж гүйцэтгүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Малын генетик нөөцийн төлөв байдлыг үнэлэх ажлыг өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд дотоодын нөөц бололцоонд тулгуурлан чанартай үнэн бодитойгоор зохион байгуулж 09 дүгээр сарын 20-нд аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газарт тайланг ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт, аймгийн хэмжээний мал сүрэгт генетик нөөцийн төлөв байдлыг үнэлэх ажлыг мэргэжил арга зүйгээр ханган дүн мэдээ, тайланг 10 дугаар сарын 01-ний дотср Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлж ажиллахыг ажлыг хэсгийн ахлагч, Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Мөнхтөр/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ

